

Монголын Нууц Товчоо ба метафор

Ж. Лувсандорж*

0. Оршил

Миний *The Secret History of the Mongols in the mirror of metaphors* өгүүлэлүүд¹ бол МНТ-ны судлалыг Соёлын Антропологитой (нүүдэлчдийн хэл ба сэтгэлгээний метафорчлалын ба, соёлын харилцааны түүх, этнографийн коммуникац) холбох гэсэн оролдлого юм. Өгүүлэлийн *Уг эш* (Chinese transliteration and Mongolian transcription) гэсэн хэсгийг би Б.Сумъяабаатарын номоос² авав. Энэ номд МНТ-ны хятад эх³ - эрдэмтэн Еэ Дэ Хуй -ийн 1908 онд хэвлүүлсэн бичвэрийг (*Yeh Te-hui text*) япон эрдэмтэн Ширатори Куракичи (1875-1942) латин үсгээр буулгаж, худам монгол үсэгийн латин галигаар сийрүүлсэнийг (Mongolian text into Latin letters) хамтад нь нэг дор оруулж, сонгодог монгол үсэгийн бичвэрийг хадаж өгсөн нь их ашигтай байна.

7². Хуулийн нэр томъёондхи метафор:

oryol(i)-jar qayas aldaltan, qabar qayas aldaltan (§ 280. L. 24 - 26)

7.1. Уг эш

Хятад эхийн галиг

yen-liè-k'(è)-siën k'è-miè-ch'è uò-ᠬuō-ér pù-kí tūo-t'ǎ-wù-luō-ā-sù uò-ér ᠬuō-lǐ íá-ér ᠬǎ-

* Карлын Их Сургууль, Өмнөд ба Төв Ази Судлалын Хүрээлэн

¹ J.Lubsangdorji, 2006, *The Secret History of the Mongols in the mirror of metaphors*, in *Mongolica Pragensia* '06, Prague, pp. 141-1618, Ж.Лувсандорж, 2007, *Монголын нууц товчоог метафорын толинд харах нь*, in: *Mongolica, An International Annual of Mongolian Studies, Vol.20 (41), 2007, p.443, ISSN 1024-3143. Section III: National Language and Literature*, p. 74 – 99.

² В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols. Transcription /Mongyol-un niyuca tobciyan. Ycsuyn galug/*. Улаанбаатар, 1990, p. 884, §280. L. 23-26)

³ “МНТ-ны хятад эх” гэгч бол монгол хэлийг хятад үсгээр галиглан бичээд товч хятад орчуулга дагалдуулсан ном юм. Худам монгол бичгээр байсан монгол эхийг 500 гаруй хятад галиг үсэг хэрэглэн монгол хэлээр буулгасан байжээ. Тэр 500 гаруй үсгийг академич С. А. Козин “китайско-монгольское письмо как национальное письмо монголов” (монголчуудын үндэсний бичиг болсон хятад-монгол бичиг) гэж нэрлээд судалгааны нэгэн боть зохиол гаргахаар зорьж байсан нь хэрэгжээгүй бололтой (үз Козин С.А. 1941, тал 8).

hǎ-sī ā-l(è)-tā-l(è)-t'án péi- l(è)-t'ū-hái hǎ-l(è)- pù- hǎ k'è-k'è-sūn tūo-t'ā-wù-luō-ā-sù

hǎ-pā-ér hǎ-hǎ-sī ā-l(è)-tā-l(è)-t'án péi- l(è)-t'ū-hái⁴

Сонгодог монгол бичигийн хэлний хөрвүүлгэ:

Kemnegsen kem-eče
Oqor bugi dutayulbasu
Orgil-iyar qayās aldaltan boltuyai
Qalbay-a kigesün dutayulbasu
Qabar qayās aldaltan boltuyai⁵

Одоогийн монгол хэлний хөрвүүлгэ:

...тогтоосон хэмжээгээр бэлтгэж, охор шидэмс дутуулбал өрөөлөөр хагас алдалтан болтугай. Халбага хигээс дутуулбал хамар хагас алдалтан болтугай.⁶

7.2. Үг хэллэгийн утга санаа

- а) *oqor bugi* Үндсэн утга: хятад эхэд *oqur büci*⁷, халх. *охор бүч*, Метафор утга (багасгал - meiosis): жаахан ч гэсэн юм, *богино оосрын төдий юм ч гэсэн*.
- б) *oryol(i)*/халх. *өр гол* Синоним хоршоо үг. Үндсэн утга: *төв, гол* 'center, middle', *өр голоор (=өрөөл) хагас* 'төв дундуур нь хуваасан шиг хагас'. Метафор утга: *тэнцүү хагас* 'ровная половина'.
- в) *aldaltan* < *alda-* 'потерять; ошибаться'; *aldal* 'потеря; ошибка, transgression, loss, blunder'; *Aldaltan* – үндсэн утга: *алдаа гаргасан этгээд* 'имеющий потеря; ошибающийся, "having a loss or mistake', метафор утга: *ялтан, гэмтэн* 'transgressor, criminal elements, the accused'. Ингээд *oryol(i)-iyar qayās aldaltan* гэдэг бол *оногдох ял шийтгэлийг тэнцүү хуваан эдлэгч ялтан* гэсэн утгатай эртний монгол хуулийн нэр томъёо болно.
- г) *qalbay-a kigesün* Синоним хоршоо үг. Үндсэн утга *хигээс* 'spoke', метафор утга (багасгал метафор): *өчүүхэн төдий ч гэсэн юм* (ганц хигээс мэт жаахан юм).
- д) *qabar qayās*/халх. *хамар хагас* Үндсэн утга: *хамарлан (хамрын гол дагуу) хуваасан шиг хагас*. Метафор утга: *тэнцүү хагас* 'ровная половина'. Ингээд *qabar qayās aldaltan* гэдэг бол *оногдох ял шийтгэлийг тэнцүү хуваан эдлэгч ялтан* гэсэн утгатай эртний монгол хуулийн нэр томъёоны синоним хувилбар болно.

Зохиогчийн хөрвүүлгэ:

а) *эхийн хэлбэрийг хадгалсан хөрвүүлгэ:*
Хэмлэн тогтоосон хэмжээнээс
Охор бүчийн төдий юм дутагдуулбал
Өрөөл хагас алдалтан (*ялтан, төлбөртөн,*)
болтугай.
Ганц хигээсийн төдий юм дутагдуулбал

⁴ В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /Mongyol-un niyuca tobciyan. Yeguiin galuz/. Улаанбаатар, 1990, р. 884, §280. L. 23 -26)

⁵ В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /Mongyol-un niyuca tobciyan. Yeguiin galuz/. Улаанбаатар, 1990, р. 884, §280. L. 24 -26)

⁶ Ц.Дамдинсүрэн, *Монголын нууц товчоо*. Улаанбаатар, 1990, 253-р хуудас

⁷ Ц.Хандсүрэн, *Цэнд гүн ба Монголын нууц товчоо*. Улаанбаатар, 1997, 646 pp. р. 642

Хамар хагас алдалтан (ялтан, төлбөртөн) болтугай.

б) ерөнхий утгын хөрвүүлгэ

хэрэв заасан хэмжээнээс өчүүхэн төдий ч гэсэн юм дутагдуулбал оногдох ял шийтгэлийг тэр хоёр ноён тэнцүү хуваан эдэлнэ.

7. 3. Хам нөхцөлдөлгө ба тайлбар

Өгөөдэй хаан их өртөө зам байгуулах зарлиг буулгаж даргаар нь Арасэн, Тогучар нэртэй хоёр ноёныг томилж, өртөө бүрд байх ажилчид, морь, тэрэг, саалийн гүү, хүнсний хонь зэрэг юмсын тоо хэмжээг заагаад хэрэв заасан хэмжээнээс өчүүхэн төдий юм дутагдуулбал оногдох ял шийтгэлийг тэр хоёр ноён тэнцүү хуваан эдэлнэ гэж хэлсэн нь юм.

Уг бичвэрийн метафор хэлцнүүдийг этнографийн коммуникацийн үүднээс үзвэл эртний монголчуудын сэтгэлгээний ба хэлэхүйн арга, түүнд суурилсан хуулийн нэр томьёонуудын өвөрмөц сонин зүйлүүдийг ойлгоход тустай болно.

Халх. *өрөөл хагас* < *өр голоор хагас* = *хамар хагас* гэсэн нэр томьёо бол маш эртний анчидын олз хуваах сэтгэлгээний арга болно. Анчид, хамтран агнасан амьтны гулууз махыг хоёр тэнцүү хэсэг болгон хуваарилах тогтсон ёстой байсан. Үүнд, гулуузын өр голын дагуу (нуруу ба хүзүү ясны гол дундуур нь хамарыг өнгөртөл цавчиж) яг 2 тэнцүү хэсэг болгон хуваадаг байсан. Орчин үеийн монгол хэлний лексик хэрэглээний дагуу зарим жишээнүүдийг үзүүлье.

Өр / гол ‘center’ гэдэг синоним үгсийн утга шилжиж *өр* ‘aorta’ болсон: *өрийг/голыг тасла*⁸ (хонь алах монгол арга). *Өр гол* гэдэг хоршоо үг авиан зүйн ижилсэлд орж *өрөөл* гэдэг шинэ үг бүтсэн: *өрөөл мах* (гулуузын хагас), *өрөөл даавуу* (ам даавууны хагас) *өрөөлийн өрөөл* гэх мэт.

Qabar/хамар гэдэг үгийн утга (*хамар нь адил хоёр талтай*) шилжиж *тэн хагас* гэдэг үг болсон: *хамар цаас* ‘ам цаасны хагас’, *хамар хашаа* ‘өрөө хашаа’. Ингээд *өр гол/өрөөл хагас* гэдэг нь юмыг дотроос нь хагаслан бодох арга, *хамар хагас* гэдэг нь юмыг гаднаас нь хагаслан бодох арга болжээ.

Aldaltan гэдэг үг МНТ-д *aldaltan baltuγai!* (: § 224, 227, 233, 280) гэсэн үйлийн холбоо үгээр олон удаа гарч байна. Тэрнийг орчуулагч нар “*нести ответственность, подвергаться законным взысканиям* (Козин), *necht' jsou potřestáni!* (Poucha), *[it] be subject to punishment* (Cleaves)” гэж метафор утгы нь аятайхан гаргасан мөртлөө § 280-д мөн тэр утгаараа байгаа холбоо үгийг үндсэн утгаар нь үгчлэн орчуулснаас эндүүрэл гарсан байна. (“орчуулгын жишээ” хэсэгт үз).

Aldaltan гэдэг үгийн үндэс *aldal* гэдэг үг бол метафор утгаараа “*transgressoin, guilt, fault, crime, punishment, penalty*” гэсэн ерөнхий утгатай, эртний монгол хуулийн чухал нэр томьёо

⁸ Хонь алах монгол арга бол Соёлын антропологиин чухал оногдохуун болохоор товч тодорхойлох хэрэгтэй: хар хүн (мясник) хонины өрийг (подложечная область) хурц хутгаар 10 см зүсэж, гарыг дотор оруулан нуруу ясны дагуу өрцийг (диафрагма) хуруугаар цоолоод голыг (аорта) хуруугаар тасладаг. Тэгж хонины бүх цус цээжин дотор хураагдсаны дараа савлан авдаг. Сүжиг сэжигч сэтгэлгээний талаар сонирхолтой ба чухалтай нь: хар хүн, амьтныг цус гаргалгүй алж байна. Хонь Дээд Тэнгэрийг харж үзээгүй амьтан юм. Хар хүн, түүний өрийг зүсэхээр дээш харуулан хэвтүүлэхэд хонь “хүн-эзэн минь намайг Тэнгэр харуулж өгч байна. Би Тэнгэрийг харах ямар азтай амьтан бэ! гэж бодсоор санаа амар бурхан болдог” гэдэг.

Чингис хааны ИХ ЗАСАГ гэдэг хуулинд “[монгол хүн] хонийг мусулманы адилаар хоолойг таслан цус урсгаж албал тэр хүнийг өөрий нь тийнхүү алтугай!” (Үзмүү. Dž. Luvsandordž, Jaroslav Vacek, Učebnice mongolštiny, Praha, 1985, p. 46-47: *Монголын хууль цааз*) гэсэн заалт бий.

байсан. Чухам ямар тодорхой ял шийтгэл өгөхийг (жишээ нь: төлбөр, торгууль, бэрээдэх, хөрөнгө хураах, цөллөг г.м.) заргач шүүгч нар тогтоож байжээ.

Арасэн Тогучар хоёр ноёны хариуцлагын тухай нэг товч өгүүлбэрээр хэлж болох заалтыг Өгөөдэй хаан дөрвөн мөр шүлэг болгож, үгийн хэлбэрийг өөрчлөн давтсан нь нүүдэлчдийн эртний *аман бичгийн хэл* (койне) –ийн чухал шаардлага байсан⁹ (Козин 1941, р. 50). Ийм уран үг яриа, сонсмогц хүний толгойд бат суугдаж, үл мартагдан үйлчлэх чадалтай байжээ. Нууц товчооны хэл бол эртний нүүдэлчид бүхэлдээ тийм айзам холбоос (ритмика и аллетрация) болсон яруу найргийн мэт хэлээр ярьдаг байсны баримт дурсгал юм. Одоогийн малчдын ярианы хэлэнд ч тийм элементүүд байгааг А. Оберфалзеровагийн хээрийн судалгааны материалаас (*Metaphorical speech and thought of the Mongolian Nomads. Analysis of live interviews*)¹⁰ үзэж болно.

7. 4. Гадаад хэлнээ орчуулсан байдал

Орос: И если впрядь у кого окажется в недочете хоть коротенькая веревочка против установленного комплекта, тот поплатится одной губой, у кого не достанет хоть спицы колесной, тот поплатится половиною носа¹¹

Герман: Wenn ... auch nur ein kurzer Strick fehlt, dann sollen sie mit einer Vermögensstrafe wie für Durchhauen des Nackens! Wenn ihnen ein Löffel oder Radspeiche fehlt, sollen sie mit einer Vermögensstrafe belegt werden, wie für Abschlagen der Nase!¹²

Чех: Kdyby ... chyběl do počtu Námi stanoveného i jen jeden krátký provaz, pak jest uložití pokutu na majetku, jako když se přesečne šíje! Bude-li jim chybět lžíce nebo paprsek kola, necht' se jim uloží pokuta na majetku jako za useknutí nosu!¹³

Англи: ...from the limit limited from Us from hence,
If they make a short cord to be wanting,
Let them be condemned to [what is called]
'cleavage [following a straight line passing] along the (?) hinder part of the neck.'
If they make a spoke of a wheel in the form of a spoon to be wanting,
Let them be condemned to [what is called]
'cleavage [following a straight line passing along]

⁹ С.А.Козин, *Сокровенное сказание, "введение в изучение памятника, перевод, тексты, глоссарии"*. М.-Л., 1941, 619 pp. p. 50

¹⁰ Alena Oberfalzerová, *Metaphors and Nomads*, Prague, 2006, 199 pp., p. 124-137.

¹¹ С.А.Козин, *Сокровенное сказание, "введение в изучение памятника, перевод, тексты, глоссарии"*. М.-Л., 1941, 619 pp. p.198.

¹² E.Haenisch, *Die Geheime Geschichte der Mongolen*. Leipzig, 1948, 196 pp. p. 147

¹³ P.Poucha, *Tajná kronika Mongolů* [Secret Chronicle of the Mongols]. Praha, 1955, 279 pp. p.226.

the nose.¹⁴
 Франц: Si, ... au regard des quantité fixées par nous,
 quelqu'un est cause que,
 Vienne à manquer un bout de corde,
 Qu'on confisque la moitié de ses biens,
 Vienne à manquer un rayon de rouse,
 Qu'on confisque la moitié de ses biens¹⁵

8. Газрын нэрэндхи метафор:

Talqun aral (§ 115),
Köde'e aral (§ 280)

8.1. Уг эш

Хятад эхийн галиг:

uò-ér-hān siē-liáng-ké uō-iá-rún t'ǎ-l(è)-hún ā-rā-lā-ch'á¹⁶
 k'è-luō-riè-nè k'uò-tiè-è ā-rā-rún¹⁷

Монгол галиг:

Orqan, Selenge qojar-un **Talqun-Aral**-ača ičurun¹⁸
 Kelüren-ü **Ködege-Aral**-un¹⁹

Монгол хөрвүүлгэ:

Орхон Сэлэнгэ хоёрын
Ой талаас буцав. **Талхун аралаас** хөдөлж...²⁰
 Хэрлэний **Хөдөө арлын** Долоон болдог...²¹

8. 2. Үгийн утга

Aral, халх. **арал**; a) island, b) peninsula, c) oasis.²² МНТ-ны дээрх хоёр зүйлд (§ 115, § 282) “peninsula” гэдэг утга нь тохирч байна. **Talqun-Aral** гэдэг бол Орхон Сэлэнгэ хоёр голын бэлчирт одоо ч байгаа их ойт хагас арлын эртний нэр байна.

Talqun гэдэг үгийн утга тодорхойгүй. Эвенк хэлний *талгин* ‘заводь, затон’²³ гэдэг үгнээс ирсэн бололтой. Энэ нутагт эрт цагт эвенкүүд нутаглаж байсан юм.

¹⁴ F.W.Cleaves, *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary. Vol. I (translation). Harvard University Press, Cambridge, Mass., London, 1982, lxx + 277 pp. p. 226-227.

¹⁵ M.D.Even Pop, R., 1994, *Histoire secrète des Mongols*. Gallimard, UNESCO, 350 pp. p. 247

¹⁶ В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /*Mongyol-un niyuča tobčiyān*. *Үсгийн галиг*. Улаанбаатар, 1990, 965 pp. p.180, § 115, L. 3

¹⁷ В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /*Mongyol-un niyuča tobčiyān*. *Үсгийн галиг*. Улаанбаатар, 1990, 965 pp. p. 890, § 282, L. 2

¹⁸ В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /*Mongyol-un niyuča tobčiyān*. *Үсгийн галиг*. Улаанбаатар, 1990, 965 pp. p.180, § 115, L. 3

¹⁹ В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /*Mongyol-un niyuča tobčiyān*. *Үсгийн галиг*. Улаанбаатар, 1990, 965 pp. p. 890, § 282, L. 2

²⁰ Ц.Дамдинсүрэн, 1990, *Монголын нууц товчоо*. Улаанбаатар, 255 pp. p. 70.

²¹ Ц.Дамдинсүрэн, 1990, *Монголын нууц товчоо*. Улаанбаатар, 255 pp. p. 254.

²² F.D.Lessing, *Mongolian-English Dictionary*. Berkeley and Los Angeles, 1960, 1217 pp. p. 48

²³ *Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков*, Том 1-2, АН СССР, Институт языкознания, Ленинград, 1975, Т. 2, стр. 157

Арал гэдэг үгийг монгол хэл одоо ч *peninsula* гэсэн утгаар хэрэглэдэг. Жишээ нь энэ нутгаас Сэлэнгэ мөрний урсгалын эсрэг 400 километрт орших Идэр, Чулуут хоёр голын бэлчирт байгаа ой бүхий хагас арлыг одоо тэр нутгийнхан *Бэлчирийн арал* 'Peninsula in confluence of rivers', *Идэрийн арал* 'Peninsula of the Ider river' гэж нэрлэж байна.

Köde'e, халх. **хөдөө**; энэ үгийн үндсэн утга нь "нутагласан айл хүмүүсгүй ба гол уснаас аглаг хээр газар".²⁴ **Kelüren-ü Ködege-Aral**, халх. **Хэрлэний хөдөө арал**; үгчлэн орчуулбал "Secluded Peninsula of the Kelüren". Хэрлэн голын урсгал Хэнтийн уулнаас эхэлж өмнө зүг урсаад зүүн хойш эргэж нэг их тохой үүсгээд зүүн тийш урсана. Тэр их тохойд орших газар (уудам тал, өндөр уулс) бол гурван талаараа голын усаар хүрээлэгдсэн тул нэг том хагас арлын байдалтай юм. Энэ хагас арал дээр орших *Долоон Болдог*, *Шилгинцэг* гэдэг хоёр газрын хооронд хааны ордон бууж байхад МНТ-г бичсэн тухай энэ бичвэр ярьж байна.

Зохиогчийн хөрвүүлгэ:

[Тэмүжин, Тоорил хан, Жамуха гурав] Орхон Сэлэнгэ хоёрын бэлчирийн "Талхун Арал" хэмээх хагас арлаас буцаруун...

Хэрлэний "Хөдөө Арал" хэмээх их тохойн [Долоон Болдог, Шилгинцэг хоёрын зуур]

8. 3. Гадаад хэлнээ орчуулсан байдал

- Орос:** и тронулись с острова Талхун-арала, что у слияния рек Орхона и Селенги в урочище Долоанболдах Келуренского Кодее-арал'²⁵
- Герман:** zogen sie wieder zurück von der Insel Talchun zwischen den den beiden Flüssen Orchon und Selengge (Haenisch 1948, p.29.)
Dolo'an Boldach, Sieben Kuppen, und Schilgintschek bei dem Werder Kode'e im Keluren²⁶
- Чех:** táhli zase zpět od ostrova Talchunu mezi řekami Orchonem a Selengou mezi misty Doloan-Boldachem a Šilginčekem u Ködeeského ostrova v Kelürenu²⁷
- Англи:** withdrew from Talqun Isle of both the Orqan and the Selengge,²⁸
at Dolo'an Bolday of Köde'e Aral²⁹ of the Kelüren³⁰

²⁴ Я. Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966, р. 706

²⁵ С.А.Козин, *Сокровенное сказание, "введение в изучение памятника, перевод, тексты, глоссарии"*. М.-Л., 1941, 619 pp. р. 105, р. 199.

²⁶ Haenisch, E., 1948, *Die Geheime Geschichte der Mongolen*. Leipzig, 196 pp. p.148

²⁷ P.Poucha, *Tajná kronika Mongolů* [Secret Chronicle of the Mongols]. Praha, 1955, 279 pp. p.54, p. 227.

²⁸ F.W.Cleaves, *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary. Vol. I (translation). Harvard University Press, Cambridge, Mass., London, 1982, lxx + 277 pp. p.48.

²⁹ In Index Nominum: *Kelüren-ü Köde'e Aral Köde'e Isle of the Kelüren* (Cleaves, 1982, p. 246.)

³⁰ F.W.Cleaves, *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary. Vol. I (translation). Harvard University Press, Cambridge, Mass., London, 1982, lxx + 277 pp. p. 228.

Франц: En retournant du bec de Talqun, au confluent de l'Orqon et de la Selenga aux Sept-Collines du bec de la Tourterelle, sur la Kerülen³¹

9. Хайрын шүлэгтхи метафор:

**ülige čegeži, üžeskülen tala, ebür-tür köl-dür oru-,
jerge-dür jergelen baγu-** (§ 208. 32-34)

9.1. Уг эш

Хятад эх:

wù-lǐ-ké chě-é-chī ch'ì-nè wù-ké-wéi
wù-chě-sī-kǔ-liáng t'ǎ-lā māu-uēi
é-siē k'hè-é-p'ì chě pi
é-pù-ér t'ú-ér k'uò-l(è) t'ú-ér uò-rá-h(ei)-sān
chě-ér-ké t'ú-ér chě-ér-ké-lién pǎo-wù-h(ei)-sān ch'ì-mǎ-yí³²

Сонгодог монгол хөрвүүлгэ:

*Ülige čegeži činü ügegüi,
Üžesküleng tal-a maγui
ese kemebe j-e bi
ebür-tür köl-dür oruγsan
jerge-dür jergelen baγuγsan čimayi³³*

“Алтан товчийн” хуулбар:

Čimayi-yi aburi üile čekeči. Činü ösküi-tür üžesküleng tei maγui ese kemebe bi. Köl-i čin-ü siberi tei. Kölüstün čin-ü ünür tei ese kemebei j-e bi. Ebür-tür köl-dür oruγsan. Jerge-dür jergelen saγuγsan čimayi-yi Jorčidai-a soyurqar-un...³⁴

Одоогийн монгол хөрвүүлгэ:

*Авир зангий чинь голсон биш.
Ариун үзэсгэлэнг чинь чамласан биш.
Өврөө дулаацуулж хөлөө хучуулсан
Өөрийн хатан чамайг...Жорчидайд соёрхох болов.³⁵*

9. 2. Үгийн утга

а) *Ülige čegeži* гэдэг үгийг хятад эхийн орчуулгад “character” гэснийг С.А.Козин орхиж зөвхөн “*čegeži*” гэдэг үгийн метафор утгаар “разум” гэж орчуулсан. МНТ-ны орчуулагчид Козиныг дагалджээ. Ш. Гаадамба³⁶ *elige* (breast) гэдэг үгээр сольсон. Нэрт эрдэмтэн Cleaves тун болгоомжтой хандаж *ülige* гэдгийг орчуулгагүйгээр авсан юм.

³¹ M.D.Even Pop, R., 1994, *Histoire secrète des Mongols*. Gallimard, UNESCO, 350 pp. p. 82 p. 248.

³² B. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /*Mongγol-un niγuča tobčiyān*. Үсгийн галиг/. Улаанбаатар, 965 pp. p. 582, § 208, l. 32-35

³³ B. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /*Mongγol-un niγuča tobčiyān*. Үсгийн галиг/. Улаанбаатар, 965 pp. p. 582, § 208, l. 32-35

³⁴ Lubsangdanjin, *Altan tobči*, The Golden Summary which relates briefly the deeds of civil governance established by ancient emperors. The Mongol chronicle of the 17th century, Ulaγanbaγatur, 1990. 177 pp. p. 65

³⁵ Ц.Дамдинсүрэн, *Монголын нууц товчоо*. Улаанбаатар, 1990, 255 pp. p. 183

³⁶ Š.Gadamba, 1990, *Mongγol-un niγuča tobčiyān*. Ulaγan-baγatur, 417 pp. p.143

Хятадын судлагч Чойжийн мэдээлснээр *ülige čegeji* гэдэг хэлц Баарин аялгуунд “маш сэргэлэн, цээжлэн тогтоох их чадвартан” гэсэн утгатай байдаг гэнэ³⁷. Гэвч тэр утга энд тохирохгүй. Лу. Алтан товчийн зохиогчид байсан монгол эхэд *aburi üile čekeči* гэж байсан бололтой. Тэр нь Нууц товчооны хятад эхийн орчуулгатай тохирч байна! Тэгэхлээр Нууц товчооны анхны эхэд *ülige čekeči* (великая честность, образцовая прямота) гэж байсны 2-р үгийг хятад эхийн галигч *chě-é-chí* гэж гэж урт? *é* эгшгээр бичсэн бололтой юм. Тэгээд хожмын судлагч нар энэ үгийг “цээж” (*čegeži*) гэж уншиж “разум” гэж орчуулсан болов уу. Ингээд Нууц товчооны *ülige čegeži* гэдэг үг бол сонгодог монгол хэлний *čegeji* биш, *ülige čekeči* (халх. *үлэг цэхч /үлэг чигч*) гэсэн үг мөн. Үгчилбэл *grandiose honest*, метафор утга нь *straightforward, frank, honest, just*. Хүний зан чанарын эрхэм дээд үнэлэлтийн хэлц үг байжээ.

- б) **Ügeküi**(халх. *үгээгүү*) гэдэг үгийн үндсэн утга *хоосон, ядуу*, метафор утга *очүүхэн, бага, сул* (чамлах үг).
- в) **tal-a** (халх. *тал*) гэдэг үгийн анхдагч үндсэн утга *side, part*; эртний метафор утга *царай (fase, physiognomy)* мартагдсан боловч одоогийн ярианы хэлний *нүүр тал хара-* “to be partial” (синоним хоршоо үг), *тал өг-* (=нүүр/царай өг-) “to do a favor or courtesy” (хэлц үг) гэдэг холбоо үгнүүдэд хадгалагдсан байна.
- г) **ebür-tür köl-dür oruγsan** Энэ хэлц монгол хэлтэнд ойлгомжтой боловч гадаадын хүнд ойлгоход тийм амар биш. Тэд энэ метафор хэлцийг үгчлэн орчуулдаг болохоор гол утга санаа нь тодорхой илэрдэггүй. Харин Д. Цэрэнсодном³⁸ *өвөр түрийд орсон* гэж хөрвүүлсэн нь эхийн санаанд ойр хүрчээ. **Ebür-tür oru-**: үгчилбэл *нөмөрсөн дээлийн энгэр талаас орж хэвтэ-* (входит в пазуху), метафор утга: *хөнжилд нь цээжин талаас нь орж хэвтэ-* (входит в постели со стороны его груди и лежат вместе с ним). **Köl-dür oru-**: үгчилбэл *нөмөрсөн дээлийн хөлд, хормойд орж хэвтэ-* (входит в ноги), метафор утга: *хөнжилд нь хөл талаас нь орж хэвтэ-* (входит в постели со стороны его ног и лежат в месте с ним). Дээрх хоёр хэлц бол *янагийн холбоонд батад орсон* (любовью крепко связанная, жить душа в душу, жить в законе) гэсэн ерөнхий утгатай хүйсийн яруу хэлц (экспресив идиом) юм. Одоогийн монгол ардын хэлэнд тэр хэлцийн оронд *хошуу холбож хол хэрэ-* (соединяться губами и сплетываться ногами), *тоонотой гэрт толгой холбож тостой тогоонд хошуу холбо-* (в юрте с круглым окошком связываться головами и в замасленном котле соединяться устами) зэрэг өргөн хэрэглэдэг хэлц үгс байдаг.
- д) **jerge-dür jergelen bayuγsan**: *bayu-* гэдэг үйл үг үгчилбэл *доошилсон 'to come or go down, to settle down'*; метафор утга: *боссон, тогтсон 'остановливаться, оседать, стоять'* (харьцуул: *ger bayuγsan* “юрта поставлена, юрта стоит”, *ayil bayuγsan* “их юрта поставлена в соседстве”). Ингээд уг хэллэгийн утга нь *миний зэрэгт зэрэгцэн боссон (равняясь к чине моего поднялась) ~ надтай эн зэрэгцсэн хатан (жена моя поднимавшийся со мной к ровной степени)* гэсэн санаа болох ба Ц. Дамдинсүрэн энэ санааг одоогийн монгол хэлэнд *өөрийн хатан чамайг* гэсэн холбоо үгээр аятайхан орчуулсан юм.

³⁷ Čoyiji, *Altan tobči*, Kökeqota, 1984, 672pp. p.283-284

³⁸ Čeringsodnam 1990 (Dalangtai-yin Čeringsodnam „*Mongyol-un niyuča tobčiyān*” - u orčiyuly-a tayilburi. Begejing. 545pp. p. 104)

е) **чамайгаа:** энэ үгийг МНТ *ċimayū* гэж бичсэн боловч Лу. Алтан товчид заахын тийн ялгалын нөхцөлийг хоёр давхарлан *ċimayū-yī* гэж бичсэн онцолборыг Нууц товчооны эхэд байгаа *ċimayū* гэдэг үгийг би, Чингис хаан үгийнхээ эх ба эцэст ойр давтан хэлсэн онцолбортой харьцуулан бодоод өөрт хамаатуулсан дотносох онцолбор гэж үзээд одоогийн монголоор *чамайгаа* гэж хөрвүүлэв.

Зохиогчийн хөрвүүлгэ:

*Ааш зангийн чинь шулуун шударгыг
Царай зүсний чинь өнгө үзэсгэлэнг
Голж чамласангүй би.
Нэг хөнжилд хамт хөлбөрч
Надтай эн зэрэгцэн өндөрлөсөн чамайгаа
Жүрчэдэйд соёрхохдоо,*

9.3. Хам нөхцөлдөлгө ба тайлбар

Их Монгол Улсыг байгуулах хэрэгт удаа дараа их гавьяа байгуулсан цэргийн ноён Жүрчэдэйд Чингис хаан, өөрийн залуу хатан Ибага Бэхи -ийг соёрхохдоо Ибага Бэхид хэлсэн үг энэ юм. Чингис хааны гол санаа бол өөрийн үзэсгэлэнт сайн хатан чамайг би голсон биш, үлэмжийн их ачтаныхаа ачийг сэтгэж чамайг өгч байгаа эрхэм дээд ёс мөн гэсэн сэнхрүүлэг юм. Чингис хаан “хайрт” хатанаасаа хагацахдаа хэлсэн үдэлтийн энэ үг бүхэлдээ хайрын дурсамжийн байдалтай юм. МНТ-ны зохиогч түүнийг эротик талаас нь шүлэглэхийг хичээжээ. Нууц товчооны нөгөө хувилбар –Алтан товчид түүнээс уран эротик мөрүүд³⁹ бий юм.

Энэ хэсгийн эцэст би МНТ-ны *ebür-tür köl-dür oruγsan* гэсэн метафор хэлцийн чех (Поухагийн) ба герман (Хайнишийн) орчуулгыг чех, герман уншигч яаж ойлгож байгааг сонирхуулахыг хүсэж байна. Германаар *an Brust und Beine herankommen* (цээж ба хөлөнд ойртсон ~ өвчүү цээж ба хөлд тулж ирсэн) гэж орчуулсныг техникийн зохиолын орчуулагчийн мэргэжилтэй 67 настай эмэгтэй Хелга Райс гуай: “*Brust (цээж) гэдэг үг герман хэлэнд зүрх, сэтгэл гэсэн үгтэй синоним болохоор бие сэтгэлд ойр дотно болсон (хайртай байсан) гэж ойлгож болох юм даа*” гэв.

jerge-dür jergelen bayuγsan гэдэгийн герман орчуулга *in die Rangordnung eingereicht hinabgestiegen* (зэрэгт эгнэж буусан) гэсэнийг цөмийн физикчийн мэргэжилтэй 40 настай эрэгтэй Штефан Райс: “*hinabsteigen* гэдэг үг бол бүүр уруудсан, доош буусан гэсэн утгатай болохоор Чингис хаан тэр хатанд дургүй болоод зэргий нь буулгасан байх” гэв.

Дээрх хоёр мөр шүлгийн чех орчуулга: “*Tebe, ktera na nohou a prsou jsi sem přišla a zařazena podle pořadí jsi sestoupila*” гэснийг монгол судлалч чех Вероника Зикмундова: *тэр хүүхэн цээжээрээ мөлхөж ирсэн, тэгээд доош буусан / snižovat se* гэж чех хүнд ойлгогдох байх” гэв.

Монгол хэлний *бауу-/буу-* гэдэг үйл үг, хоёр үндсэн утгатай. Тэр хоёр утгынхаа дагуу бас хоёр өөр утгат метафоруудыг бүтээнэ: 1) доош чиглэсэн хөдөлгөөн, үндсэн утга: *шувуу бууж байна* “птица спускалась”, метафор утга: *сайд бууж байна* “министр снизился в

³⁹ Үз 8.1. “Уг эш”

должности”. 2) тэр хөдөлгөөний эцсийн үр дүн – зогсолт/стояние, үндсэн утга: *хаа буусан бэ?* “где вы остановились?”, метафор утга: *манайх энд буусан* “мы здесь расположились на жительство/юрта уже стоит”. МНТ-ны дээрхи хэлцийн метафор, энэ 2-р утгаар байна. *Тэднийх өволжөөндөө буусан* гэсэн монгол өгүүлбэрт “*Его семья навьючивали юрту. Откочевали. И на зимовке. на своей усадьбе соорудили юрту. Теперь их юрта уже стоит*” гэсэн олон өгүүлбэрээр илрэх санаа шингэжээ. Метафорчлал, метафор хэлцийг этнографийн коммуникацийн талаас анхааран үзэх нь тун чухалтай байна.

9.4. Гадаад хэлнээ орчуулсан байдал

- Орос:* Я не пренебрегал ни разумом твоим, ни красотою. И если я от сонма находящихся у лона моего и подножия ног моих отдаю тебя,...Чжурчедаю,⁴⁰
- Герман:* Ich habe von dir nicht gesagt, daß du kein gutes Wesen hättest oder daß deine Erscheinung und dein Gesicht übel wäre. Dich, die du an Brust und Beine herangekommen und in die Rangordnung eingereiht hinabgestiegen warst, schenke ich dem Dschurtschedai.⁴¹
- Чех:* Neřekl jsem o tobě:
Má nedobrou povahu,
má zjev a obličej špatný.
Tebe, která na nohou a prsou jsi sem přišla a zařazena podle pořadí jsi sestoupila, daruji Džurčedejovi.⁴²
- Англи:* I have not said [unto myself] that thou [art] without thine *ülig*e and bosom and that [thou art] bad [as to thy] beauty and appereance. When I present unto Jürčedei thee who art ‘ entered into [my] breast and into [my] legs ’ and who art ‘ descended,’ taking place in the row, being mindful of the great principle,⁴³
- Франц:* e n'ai point dit
Que tu étais dépourvue de sensibilité,
Ni que tu étais de médiocre beauté.
Toi qui as entrée dans mon sein et mes jambes,
Toi qui as campé dans le rang [des épouses impérialles], En t'accordant au Djourchète⁴⁴

⁴⁰ С.А.Козин, *Сокровенное сказание, “введение в изучение памятника, перевод, тексты, глоссарии”*. М.-Л., 1941, 619 pp. p. 162

⁴¹ E.Haenisch, *Die Geheime Geschichte der Mongolen*. Leipzig, 1948, 196 pp. p. 96

⁴² P.Poucha, *Tajná kronika Mongolů* [Secret Chronicle of the Mongols]. Praha, 1955, 279 pp. p. 152

⁴³ F.W.Cleaves, *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary Vol. I (translation). Harvard University Press, Cambridge, Mass., London, 1982, lxx + 277 pp. p. 149

⁴⁴ M.D.Even 1994, *Histoire secrète des Mongols*. Gallimard, UNESCO, 350 pp. p. 176

10. Дургүйцэлийн модолтай метэфор:**Mergid-ün čorγan ger (§115)****10.1. Уг эш****Хятад эх:**Miè-ér-k'ì-tün **ch'ò-ér-hān ké-ér** ...⁴⁵**Сонгодог монгол хөрвүүлгэ:**Merkid-ün **čorγan ger** soγoliγulžu....⁴⁶**Одоогийн монгол хөрвүүлгэ:**

Олон мэргидийн

Оцгор гэрийг эвдэж

Олигтой эмсийг олзолж...⁴⁷-*цуурхай амтай овоохой гэр...⁴⁸**Тэмдэглэл:**

Нууц Товчоо судлагчдын čorγan / čorqan = čōryan / čurqan гэх мэт галилаж байгаа энэ үг, хятад эхдээ хадмал орчуулгагүй, орчуулагч судлагчид олон янзаар ойлгодог үг юм. Зарим нь одоогийн монгол хэлний *цорго* (tube, pipe, sprout) гэдэг үгтэй холбож үзээд шовх оройтой (островерхая) гэр, зарим нь *цуурга* (lock) гэдэг үгтэй холбож үзээд *цуургатай гэр*, зарим нь *цуурхай* (hole, rent, rip, torn, ripped) гэдэг үгтэй холбож *цуурхай үүдтэй овоохой*, зарим судлагч манж хэлний *zurγan* (ministry) гэдэг үгтэй холбож *албаны сууц* гэх мэтээр орчуулдаг.

Čorγan / čurqan гэдэг үг орон сууцны нэрэнд тохиолдож байгаа болохоор орон сууцыг хийх гол материал *шургааг(ан) / чургааг(ан)* 'pole' гэдэг үгтэй холбон үзэх нь үгийн гарал ба утгын талаар оновчтой болно гэж бодож байна.

10.2. Үгийн утга

Халх. *шургааг(ан) / сургааг(ан)*, сонгодог монгол: *šurγay / siruy* 'pole, long mast, stake' (Lessing, 1960, p.718, 758), эртний түрэг: *siryu* 'шесть, жердь'⁴⁹, манж-тунгус: *сѣранг / шѣранг* 'жердь'.⁵⁰ Эртний монгол хэлэнд *š* авиа ялгаран гараагүй, түүнийг *č* авиа орлож байсан⁵¹ болохоор МНТ-ны *čorγan / čurqan* гэдэг үг бол сонгодог монгол хэлний *šurγay / siruy* гэдэг үгийн эртний дуудлагаас ирэлтэй гэж бодогдоно.

Шургааг бол залуу шинэс модны холтостойгоо байгаа их бие (ствол молодой лиственницы с корой, грубые необработанные жерди), нүүдэлчдийн малын хащааны материал юм.

Шургааган гэр: үндсэн утга: *шургааган байшин*, 'изба'. Метафор утга (модал дургүйцэл): 'тагз, амбаар, 'хижина, хибара'.

⁴⁵ В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /Mongγol-un niγuča tobčiyān. Үсгийн галиул/. Улаанбаатар, 1990, 965 pp. p.179, § 115, L. 2

⁴⁶ В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /Mongγol-un niγuča tobčiyān. Үсгийн галиул/. Улаанбаатар, 1990, 965 pp. p.179, § 115, L. 2

⁴⁷ Ц.Дамдинсүрэн, *Монголын нууц товчоо*. Улаанбаатар, 1990, 255 pp. p. 70.

⁴⁸ Ш.Гадамба, *Mongγol-un niγuča tobčiyān*. Улаан-баатар, 1990, 417 pp. p. 304

⁴⁹ *Древнетюркский словарь*, 1969, АН СССР, Институт языкознания, Ленинград. p. 550

⁵⁰ *Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков*, Том 1-2, АН СССР, Институт языкознания, Ленинград, 1975, т.2, p. 75

⁵¹ Жишээ нь. эрт. мо. *čādzan* (со.мо. čaγajan), халх. *цааз(ан)*, буриад. *сааз(ан)* - үндсэн утга нь "хууль", 'prohibition, law, punishment' < санскрит. *dāsana*. Эрт. мо. *čibaγanča / sibayansa*. халх. *чавганц*, буриад. *шавганса* - 'nun' < согд. šmn' nch.

Зохиогчийн хөрвүүлгэ:

Mergid-ün siruγun (>šurγay-un) ǰer-i ᠵоуи ᠵоуиᠯᠵᠢ⁵², халх. *Мэргидийн шургааган гэрийг цоо цоолж (цөм цохиж)*

10.3. Хам нөхцөлдөлгө ба тайлбар

Энэ хэлц бол нэг олзлогдсон гоо хүүхнийг [Чингис хааны авааль хатан (legitimate wife)] чөлөөлөхийн төлөө Монгол-Хэрэйдийн хамтарсан 30 мянган цэрэгт арми, Мэргид аймгийг гэнэт дайран орж⁵³ ялалт хийгээд маш урамтай буцсан тухай зүйр цэцэн үг мэт дотоод яруу (экспрессив) найруулгатай хоёр мөр уран хэллэгт (олон мэргидийн олиггүй гэрийг эвдэж олигтой эмсийг олзолж буцсан) тохиолдож байна.

Мэргидүүд⁵⁴ Өвөрбайгалын ойт хээр нутагт байсан болохоор зарим нь хээр талын монголчуудын адил исгий гэрт, зарим нь ойн арадын адил модон байшинд суудаг байсан бололтой. Тэдний байшин голдуу шургаагаар барьсан эгэл тагз байшин (примитивные домики) байсан. Тийм сууц, исгий гэртэн нүүдэлчдэд таалагддаггүй болохоор *шургааган гэр* гэж доромж найруулгын үгээр нэрлэсэн бололтой. Мэргидүүдэд байшин байсан гэж ойлгогдох нэг үндэслэл Нууц Товчооны §112-т байгаа нэг айлын үүдний тухай бичвэр юм: “*Belgütei-yin eke tere ayil-dur b-yu kemen jiyaydaju Belgütei eke yügen abur-a odcu ger-tür inü Belgütei barayun egüden-ber oruqu-luy-a eke inü nabtarqai nekei degeltei jegün egüden-ber yaruyad*” (It being shewed, saying, “The mother of Belgütei (a half-brother of Temüjin) is in that ayil,” Belgütei going for to take his mother, with Belgütei’s entering into her tent by the right door, his mother-[clothed] with a raiment of tattered sheepskins-being gone out by the left door).⁵⁵

Хуучин цагийн исгий гэрийн үүдний тухайд баруун үүд (үүдийг хааж унжуулсан исгийн баруун завсар), зүүн үүдээр (үүдийг хааж унжуулсан исгийн зүүн завсар) хоёр хүн (хүүхэд) нэгэн зэрэг орж гарах боломжийг би үгүйсгэхгүй. Гэвч тийм завсраар хоёр том хүн нэг нь нөгөөгөөсөө зугтааж бие биедээ мэдэгдэлгүйгээр нэг зэрэг орж гарах боломжгүй. Тэгэхлээр Бэлгүтэйн орсон айл бол баруун ба зүүн хоёр үүдтэй байшин байж таарна.

10.4. Гадаад хэлнээ орчуулсан байдал

Орос: у Меркитов
Крутоверхие юрты разбили,
Знатных красавиш пленили
[Клином сшибли замки у юрт, красавиц для себя забрали]

⁵² МНТ-ны энэ текстэд *soγoljūl-* гэдэг хэцүү үг байна. Лессингийн тольд байгаа ᠵоуи ᠵоуиᠯᠵᠢ- ‘to pierce through’ гэдэг үг, тэрний утгыг нарийн тодорхой үзүүлж байх шиг байна. Авианы хэлбэржилт нь ч ойр юм. Үз Lessing 1960, p. 195, in word СОГУ /ЦОО.

⁵³ Гумилев 1989 (Гумилев Л.Н., Древняя Русь и Великая степь, Москва, 765pp.), p. 424-427: „Троянская война“ на Селенге

⁵⁴ “Видимо, меркиты были не монголы или тюрки, а тогда остается только самодийская группа, к коей их и следует причислить” (Гумилев 1989, с.426).

⁵⁵ F.W.Cleaves, *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary. Vol. I (translation). Harvard University Press, Cambridge, Mass., London, 1982, lxx + 277 pp. p. 47

- знаменитых...(Иначе: снесли их крутоверхие юрты).]⁵⁶
- Герман: Tataren=Jurten der Merkit umgestürzt und die vornehmen Frauen geraubt⁵⁷
- Чех: Merkitů špičaté jurty rozbili, vznešené ženy uloupili,⁵⁸
- Англи: of the Merkid, Overtyring the *čorqan** tents, Ravishing the glorious women, (* This word, not glossed, is not elsewhere attested. In § 124 below, however, there is found the expression *čo 'oryatai tergen-i* (acc.) „the cart having a lock.“ It may, therefore, be that *čorqan*= *čôryan*<*čo 'oryan* „lock.“ If so, the expression *čorqan ger* in this passage may mean „lock-tents,“ i.e., „tents with locks.“)⁵⁹
- Франц: jetèrent à bas les grossières demeures des Bons-Viseurs et capturèrent leurs femmes splendides⁶⁰

11. Яруу хэлцийн жишээ:

oro-ban hoγtorγu bolyagda-, ebür-jen hemtülde- (§105)

11.1. Уг эш

Хятад эх:

**uò-rá-pān huō-h(ei)-t'uō-ér-hū péi-l(é)- hǎ-h(ei)-ta-,
é-pù-rǐ-ién hám-t'ún-l(è)-tié-**⁶¹

Сонгодог монгол хөрвүүлгэ:

*Oro-ban oγtorqu bolyagday-a bi, ebür-i-iyen emtültege bi*⁶²

Одоогийн монгол орчуулга:

Өрий минь өвтгөв

Өврий минь хоослов⁶³

Ороон хоосон болгуулав би

Өврөөн өмтлүүлэв би⁶⁴

11.2. Үгийн утга

Ebür/халх. **өвөр**; Үндсэн утга: *дээлийн өвөр*/пазуха, Метафор утга: “*нөмөрсөн хувцас*

⁵⁶ С.А.Козин. *Сокровенное сказание, “введение в изучение памятника, перевод, тексты, глоссарии”*. М.-Л., 1941, 619 pp. p. 105.

⁵⁷ E.Haenisch, *Die Geheime Geschichte der Mongolen*. Leipzig, 1948, 196 pp. p. 29

⁵⁸ P.Poucha, *Tajná kronika Mongolů* [Secret Chronicle of the Mongols]. Praha, 1955, 279 pp. p. 54

⁵⁹ F.W.Cleaves, *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary. Vol. I (translation). Harvard University Press, Cambridge, Mass., London, 1982, lxx + 277 pp. p. 48

⁶⁰ M.D.Even 1994, *Histoire secrète des Mongols*. Gallimard, UNESCO, 350 pp. p. 82.

⁶¹ В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /*Mongγol-un niγuᠰa tobčiyān. Үсгийн гасиул*/. Улаанбаатар, 1990, 965 pp. p. 150, § 105. l. 4, l. 6

⁶² В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /*Mongγol-un niγuᠰa tobčiyān. Үсгийн гасиул*/. Улаанбаатар, 1990, 965 pp. p. 150, § 105, l. 4, l. 6

⁶³ Ц.Дамдинсүрэн, 1990, *Монголын нууц товчоо*. Улаанбаатар, 1990, 255 pp. p. 62

⁶⁴ Ш.Чоймаа, *Монголын нууц товчоон*, Эхийг шинээр буулгаж тайлбар хийсэн Ш. Чоймаа, Монголын түүхэн сурвалж бичгийн чуулган, [30 боть], 1-р боть, Улаанбаатар, 2006, 240 pp. p. 56

хунарын дотоод нь”, өвөртлө- “нөмөрсөн хувцас хунарын дотор агуула-“⁶⁵, яруу найргийн метафор: *өвөртхи* «өвөрт агч юм, өвөрт хамт байгч хүн, нэгэн хөнжил хамт нөмрөгч (эхнэр).

Oytorqu гэдэг үгийг хөрвүүлэгч, орчуулагчид монгол хэлний *огторгуй* < *огт оргүй?* (хоосон) гэсэн үгтэй холбож боддог шиг байна. Энэ үгийг одоогийн монгол хэлний *оготор* *богинохон болсон, тайрсан, хугарсан*⁶⁶ гэдэг үгтэй холбож үзвэл уг шүлэгийн дараахи мөрийн *emtültege* гэдэг үгтэй утга хослох шүлэгийн холбоо мэдрэгдэнэ.

Emtültege гэдэг үг бол одоогийн монгол хэлний *эмтлэгдэ-, эмтэрэ-* (хагара-, хугара-) гэсэн үг мөн бололтой. Ингээд

Ori-ban oytorqu boluyday-a bi гэдэг бол “ор минь оготор болгогдов ~ оры минь хугалав ~ оры минь онхолдуулав” (метафор утга: *эхнэрий минь булаав*) гэдэг өвөрмөц хэлц;

Ebür-i-iyen emtültege bi гэдэг нь “өвөр (хөнжил) минь эмтлэгдэв ~ өвөрий минь (хөнжилий минь) эмтлэв ~ хөнжилий минь / өм авав, тасчив” (метафор утга: *эхнэрий минь булаав*) гэсэн өвөрмөц хэлц аж.

Зохиогчийн хөрвүүлгэ:

Оры минь хугалан авав
Хөнжилий минь өмлөн авав
(Оры минь оготорлов
Өвөрий минь өмлов).

11.3. Хам нөхцөлдөлгө ба тайлбар

Залуу Тэмүжин (ирээдүйн Чингис хаан) гэрлээд удаагүй байтал Мэргид нар довтлон ирж түүний эхнэрийг булаан авсан (§102). Тэмүжин өөрийн анд Жамухад элч илгээж түүнээс цэргийн тусламж хүссэн. Дээрх үгс бол Жамухад тэр элчээр хэлүүлсэн Тэмүжиний үгсийн (уран шүлэгийн) хэсэг юм. Тэмүжиний хэлүүлсэн үгэндхи өвөрмөц хэлцийн яруулиг нь (экспрессивность) ямар зэргийн хүчтэй үр дүн дагуулж авчирсан тухай дээр дурдсан тайлбарт (9. 3. Хам нөхцөлдөлгө ба тайлбар) үзэмүү.

11.4. Гадаад хэлнээ орчуулсан байдал

Орос: *Ложе мое – воздух пустой,*
 В сердце зияет глубокая рана
 (Ложе мое обращено в пустой воздух, Лоно (грудь) мое ущерблено).⁶⁷

Герман: *Von meiner Brust ist mir die Hälfte fortgerissen*
 worden, ..mein Bett ist mir geräumt worden⁶⁸

Чех: *postel mi vyprázdnili, mé hrudí púle mi byla urvána.⁶⁹*

Англи: *As to my bed,*
 I was made to be empty.
 As to my breast,

⁶⁵ Я. Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966, р. 429-430

⁶⁶ Я. Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966, р. 407

⁶⁷ С.А.Козин, *Сокровенное сказание*, “введение в изучение памятника, перевод, тексты, глоссарии”. М.-Л., 1941, 619 pp. р. 99.

⁶⁸ E.Haenisch, 1948, *Die Geheime Geschichte der Mongolen*. Leipzig, 1948, 196 pp. p.25

⁶⁹ P.Poucha, *Tajná kronika Mongolů* [Secret Chronicle of the Mongols]. Praha, 1955, 279 pp. p. 46

I have been rent in twain.⁷⁰

Франц: Et m'ont laissé avec mon lit vide;
Ils ont brisé ma poitrine;⁷¹

12. Доромжлолын өнгөтэй метафор:

kürdün-ü tuyul-un belčigel-dür ese kürügsen (§194)

12.1 Уг эш

Хятад эх:

kü-ér-tūo-né t'ü-hū-lún pié-l(è)-chi-é-l(è)- t'ü-ér-é-siē kū-ruō-k'(è)- siēn é-miè t'ä-yáng⁷²

Сонгодог монгол хөрвүүлгэ:

kürdün-ü tuyul-un belčigel-dür ese kürügsen em-e tayang⁷³

Одоогийн монгол хөрвүүлгэ:

Жирэмсэн эмийн шээх газраас хол яваагүй.

Жижиг тугалын бэлчих газраас гарч үзээгүй

Эм Таян зурх алдаж⁷⁴

12.2. Үгийн утга

Үгийн гарал:

kürdün халх. хүрд(эн) 'circle, cicle'; шилжвэр утга нь тэргэний дугуй 'wheel, колесо' гэдэг үг бол **küriyen**, халх. хүрээ(н) "ограда, изгородь, огороженное место, двор; круг, окружок" гэдэг үгтэй төрөл. *Kürdün* гэдэг үг бол энэ хам бичвэрт тугалын жижиг хашааны (дворик для телят) эртний нэр мөн гэж бодогдож байна. Малын сүүг ашиглахын төлөө төлийн (хурга, тугал) жижиг хашаа заавал байсан байх хэрэгтэй. Тал нутагт бол тийм хашаа нь дээс, сур, бургас зэрэг хөнгөн материалыг сүлжиж хийсэн зөөврийн хашлагануудаас (prouteny plot, fens, enclosure, shield, screen; railing) бүтдэг.

Kürdün-ü tuyul Үндсэн утга: хүрээний (хашааны~зэлний) тугал "the calf of the hedge /fence/ enclosure/ pen". Метафор утга: саалийн хугацааны тугал /телёнок дойного периода коровы/.

Kürdün-ü tuyul-un belčigel "пастбище телят дойных коров / пастбище телят в телятнике/ бол малчны гэрийн эргэн тойрондхи зэлний тугалын жаахан талбайт (ганц нэг зуун метрийн) доторхи бэлчээр юм. Үнээний сүүг сааж ашиглах нүүдэлчдийн арга бол тугалыг шөнө тусгай хашаанд (*kürdün*) хашиж өглөө нь тэдний эхийг саадаг. Үнээг бэлчээрт явсны дараа тугалуудыг хашаанаас гаргаж гэр хашааны орчмын бэлчээрт гаргадаг. Ингээд **kürdün-ü tuyul-un belčigel-dür ese kürügsen em-e tayang** (буквально "баба Таян не достигший до пастбище телят в изгороди или дойных коров"), доромжилсон метафор

⁷⁰ F.W.Cleaves, *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary. Vol. I (translation). Harvard University Press, Cambridge, Mass., London, 1982, lxx + 277 pp. p. 39.

⁷¹ M.D.Even Pop, R., 1994, *Histoire secrète des Mongols*. Gallimard, UNESCO, 350 pp. p. 76.

⁷² В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /Mongyol-un niyuča tobčiyān. Үсгийн галиг/. Улаанбаатар, 1990, 965 pp. p. 483, § 194, l. 19, l. 20

⁷³ В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /Mongyol-un niyuča tobčiyān. Үсгийн галиг/. Улаанбаатар, 1990, 965 pp. p. 483, § 194, l. 19, l. 20

⁷⁴ Ц.Дамдинсүрэн, *Монголын нууц товчоо*. Улаанбаатар, 1990, 255 pp. p. 156.

утга: *эрх танхи, мэдлэг туршлагагагүй* (изнеженный, избалованный) .

Зохиогчийн хөрвүүлгэ:

Хашааны тугалын бэлчээрт эс хүрсэн эм Таян (~тансаглахаас өөр юм мэдэхгүй ордоны эм -Таян)

12.3. Хам нөхцөлдөлгө ба тайлбар

Чингис хаан, Найман улсын зүг морилов. Найманы Таян хаан айж, улсынхаа цэргийг 1000 хүртэл км ухраан зугтах аргаар монголчуудын цэрэг ба морийг ядраасны дараа тэдэнтэй дайныг эхлэх санал хэлсэнд Найманы цэргийн удирдагч хаанхүү Хүчүлүг Хан их уурлаж эцэгийгээ эсэргүүцэн доромжлох үгийг хэлсний хэсэг нь энэ юм. Тэр, хаан эцгийгээ *зүрх ядсан эм Таян* гэж доромжлов.

Орон зайн хөдөлгөөн, нүүдэлчдийн сэтгэлгээнд чухал байрыг эзэлнэ. Хүний тухайд, бодох чадвар нь сайн, ухаантай хүн гэж магтахад “хол явсан, газар орнуудыг үзсэн хүн” гэсэн утгатай хэлц үгээр, бодох чадвар нь муу, тэнэг хүн” гэж доромжлоход “хол явж үзээгүй, газар орнуудыг үзээгүй хүн” гэсэн утгатай хэлц үгээр хэлдэг. Мэдлэгтэй, туршлагатай, ухаантай хүнийг “юм үзэж нүд тайлсан хүн” (үндсэн санаа нь *холын газар орнуудаар явж юм юм үзэж ухаан суусан*) гэнэ. Түүний эсрэг хэлц нь “юм үзэж нүд тайлаагүй хүн” юм. Тийм хүнийг уран сайхны хэтрүүллийн аргаар “эмээлээсээ өндөр даваа даваагүй, эхнэрээсээ өөр хүнийг танихгүй хүн”, *жирэмсэн эмийн шээх газраас хэтрээгүй, зэлний (хүрдний) тугалын бэлчих газарт хүрээгүй хүн*” гэдэг аж.

12.4. Examples of translations into foreign languages

Орос: Так разглагольствует **баба Таян**,

Та, что подальше еще не ходила,

Нежели до-ветру баба брюхатая.

Дальше еще и не хаживал он,

Нежели в поле теленок кружонный⁷⁵

[“Не из трусости ли прислал ты такое предложение, баба Таян,

который не выходил из дому даже на расстояние отхожего места

для беременной бабы; не доходил даже на расстояние бега

кружонного теленка (телечья “кружонная болезнь” или “вертечка”)]⁷⁶

Герман: Hat uns diese Worte nicht das **Weib Tayang** sagen

lassen, wo es Angst bekommen hat? Tayang, der

noch nicht so weit hinaus gegangen ist, wie an

dem Platz,wo eine schwangere Frau uriniert, der

noch nie zum Weideplatz der radhohen Kälber

gekommen ist.⁷⁷

Чех: **baba Tajang-chan,**

nedošel ani tak daleko,

⁷⁵ Козин *kürdün* гэдэг үгийг *to circle* гэж авсан, эсвэл *kürid* “moth” гэдэг хорхойтой хобож үзсэн бололтой.

⁷⁶ С.А.Козин, *Сокровенное сказание*, “введение в изучение памятника, перевод, текста, глоссарии”. М.-Л., 1941, 619 pp. p. 146.

⁷⁷ E.Haenisch, *Die Geheime Geschichte der Mongolen*. Leipzig, 1948, 196 pp. p.80

kde těžotná žena močí,
nedošel ani tak daleko,
kde telata jak kolo vysoká se pasou.⁷⁸

Англи: Which is not yet gone out to the place where a woman heavy [with child] pisseth;
Which is not yet arrived at the pasture of the calf of the wheel⁷⁹ (as the calf which, during the day, is tied to the wheel of a cart in the vicinity of the tent in order to prevent it from following its mother and sucking her milk, because a cow which has a calf is milked every day.⁸⁰

Франц: **Cette femmelette de Tayang,**
 Qui n'est jamais sorti si loin qu'urine une femme enceinte, **Qui n'est jamais allé si loin que pâture un veau qui tête encore**⁸¹

13. Эртний соёлын үг:

qara'utai / qala'utai / (§ 100, § 6), ölzige / öljige (§ 6):

13.1. Уг эш

Хятад эх:

-hā-lā-wù-t'ái t'īē-ér- kǎ-nè uán-l(è) chī-ké-tié nǐ-k'ān uò-k'ín sā-yīn pèi-yóu;
 -péi-k'ān hǎ-rā-wù-t'ái t'īē-ér- kiēn-t'ú-ér wù-nè-uēn-(è)-chou⁸²

Сонгодог монгол хөрвүүлгэ:

-nigen qarayutai tergen-ü ölzige-de nigen ökin sain bijü;
 -büken qarayutai tergen-dür unuyulju⁸³

⁷⁸ P.Poucha, *Tajná kronika Mongolů* [Secret Chronicle of the Mongols]. Praha, 1955, 279 pp. p. 126

⁷⁹ Cleaves –ийн тэргэний дугуйгаас одоржши уяатай байдаг тусал “the calf which, during the day, is tied to the wheel” гэсэн тайлбар бүүр буруу болов. Үнэн зөв ойлгох, орчуулахад Соёлын антропологийн мэдлэг туслах тул үнээ саах нүүдэлчдийн аргыг товч тодорхойлъё:

-Тугалыг хашаанаас гаргаж эхэд нь хөхүүлнэ. Эх нь ивэлнэ (тугалынхаа дүр, үнэр, амт /долоож мэдрэх/, хүртэхүйг мэдэрсэн эх, дэлэндээ сүү буулгана). Үнээ ивэлмэгц тугалыг татаж хашаа, тэргэний дугуй зэргийн босоо ханалиг хавтгай юмнаас түр уяна. Сүүг саана. Саалгаж байгаа үнээ, уяатай тугалаа долоон тайван зогсоно. Сүү гарахгүй болмогц тугалыг тавьж дахин ивэлгэнэ. Нэг үнээг ингэж 3–4 удаа ивэлгэх нь сүүний гарцыг нэмэгдүүлэх арга аж. Тугалыг тийнхүү босоо ханалигаас богино оосроор уядаг нь учиртай. Үнээ тугалдаа тэмүүлэн займарч хөхөөн өгөвч босоо ханалиг юм, богино уяа хоёул саад хийгээд тугалын ам . эхийн хөхөнд хүрэх боломжгүй болно. Хэрэв жишээ нь тугалыг гадаснаас уявал үнээ займран хөдөлж тугалаа хөхүүлэх боломжийг олж, саах ажилд саад учруулна.

⁸⁰ F.W.Cleaves, *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary. Vol. I (translation). Harvard University Press, Cambridge, Mass., London, 1982, lxx + 277 pp. p. 123.

⁸¹ M.D.Even For, R., 1994, *Histoire secrète des Mongols*. Gallimard, UNESCO, 350 pp. p. 153. Франц орчуулга хамгийн оновчтой ба ойлгомжтой байна.

⁸² В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /Mongyol-un niyuča tobčiyān. Үсгийн галиг/. Улаанбаатар, 965 pp. p. 11, § 6, l. 2 ; p. 134, § 100, l. 3.

⁸³ В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols*. Transcription /Mongyol-un niyuča tobčiyān. Үсгийн галиг/. Улаанбаатар, 965 pp. p. 11, § 6, l. 2 ; p. 134, § 100, l. 3.

Одоогийн монгол хөрвүүлгэ:

-тэрэгний мухлагийн өмнө нэг сайхан охин сууж явна.

-Хуагчин эмгэн, Бөртэ үжинийг бүхээгтэй тэргэнд оруулж бөөр алаг үхэр хөллөж⁸⁴

Тэмдэглэл:

Монгол хэлний хятад үсгээр⁸⁵ *hā-lā-wū-t'ái* ба *hā-rā-wū-t'ái* гэж бичсэн энэ үгийг, хятад орчуулгад *qara* 'black' гэж орчуулсан болохоор орчуулагч нар түүнийг давтдаг. Тэгээд *qaraqutai tergen* гэдэгийг Марко Пологийн тэмдэглэлд хэлсэн "борооны ус нэвтрэхгүй хар эсгийгээр бүрсэн тэрэг" гэдэгтэй холбож тайлбарладаг. Марко Пологийн "хар эсгийгээр бүрсэн" гэдэгийг хаадын *öljigetei qara'utai tergen* (свадебный экипаж) гэдэг үгэнд биш, ердийн *büken qaraqutai tergen* (халх. *бүхэгт хасаг тэрэг*) гэдэг үгэнд холбогдуулж болох юм.

13.2. Үгийн гарал ба утга

a) *qala'u* / *qara'u* Би энэ үгийг эртний соёлын харилцааны чухал үг *qara* < **carr*, *qara'u*, *qara'utai* < *chariot* (колесница) мөн гэж итгэж байна. Слав зэрэг энэдхэг-европ хэлнүүдийн *кара*, *карета*, *колесо*, *kolo*, *kelan*, *hvel*, *car/carr*, *čakra* зэрэг үгсийг гаралын хобоотой гэж үздэг⁸⁶. Монгол хэлний *qar-a terge* / сүйх тэрэг (карета), *харгуй* (өргөн тодорхой зам, тэргэн зам), *гархи* / *горхи* / *голхи* 'ring, annular', *хасаг* 'hoop, rim of a wheel, cart', *цагариг* 'circle, hoop' гм. үгстэй гарлын холбоотой байна.

МНТ-д гарч байгаа *qala'utai* / *qara'utai* гэдэг үг бол эрт цагт баруун зүгийн хүмүүс (Скит/Скиф) төв азид авчирсан хөнгөн тэрэгний нэр юм. Үндсэн утга нь *wheel*, шилжвэр утга нь хөнгөн тэрэг (*карета* / *колесница*).

Тэрэгний дугуйны нэр МНТ-д *qala'u*, *qara'u*, *kilgün* / *kilyun* (§ 214, l. 52), *qasay* (§ 64, l. 3) – ийм 4 янзаар гарч байна. Эдгээр хэлбэрүүдээс түрэг, монгол хэлнүүдийн ба монгол аялгуунуудын хоорондхи гийгүүлэгчийн сэлгээний⁸⁷ *lambdaism* (*qala'u*, *kilyun*), *zetacism* (*qasay*), *rhotacism* (*qara'u*) – хэмээх авианзүйн үзэгдэл ил харагдана. Эрт нэгэн цагт Төв Азид нэвтэрсэн тэр тэрэгний дугуй нь гол (axle) дээрээ эргэдэг, олон хигээстэй тул хөнгөн, эрхэм чухал юм байсан. Түүнээс өмнөх үеийн нүүдэлчдийн тэрэгний дугуй нь голтойгоо хамт эргэдэг, хигээсгүй, хүнд юм байсан (тэр, одоо ч монголын малчдын хэрэгцээнд хэвээрээ явж байна). Тийнхүү тээврийн хэрэгсэлд "хувьсгал" гаргасан дугуйтай хөнгөн тэргийг монголчуудын дээдэс уг нэрээр нь *qara*, *qara'utai* (*carr*, *карета*) гэж нэрлэн авсанаас зайлахгүй биз. *Qara'utai* / *харуутай* гэдэг монгол үг, энэдхэг-европ хэлнүүдийн *карета* / *chariot* / *la carroza* / *de char* гэдэг үгстэй тун адил сонсогдох биш үү?

⁸⁴ Ц.Дамдинсүрэн, *Монголын нууц товчоо*. Улаанбаатар, 1990, 255 pp. p. 26 ; p. 55

⁸⁵ МНТ-ны эхийг бичсэн хятад галигийг монгол хэлний орчуулагч Цэнд гүн "*mongyol kelen-ü kitad üsiig*" гэж нэрлэсэн ба С.А. Козин "*китайско-монгольское письмо как национальное письмо монголов*" (Козин 1941. p.8) гэж нэрлэжээ.

⁸⁶ Үз Václav Machek, *Etymologický slovník jazyka českého*, Praha, 1997, p. 241: *kára*, p. 242: *kareta*, p. 269-270: *kolo*.

⁸⁷ Олон хэлний хооронд гийгүүлэгч сэлгэх ёсонд, нэг хэлний зарим гийгүүлэгч (голдуу [r]), [l] болон хувирахыг ламбдаизм; [z] болон хувирахыг зетаизм; [z], [s] мэтийн гийгүүлэгч [r] болон хувирахыг ротацизм хэмээн нэрлэнэ. Үзэмүү Ахманова 1969, p. 158, 213, 392.

Хөнгөн тэргийг Өвөрмонголын монгол хэлний тайлбартай тольд *qar-a terge(n) = seüke terge*⁸⁸ (Norjin 1999, p. 1246), *qasay terge(n) = тэнхлэгээр эргэдэг богино хүрдтэй модон тэрэг*⁸⁹ (Norjin 1999, p. 1209) гэж нэрлэдэг ба халх аялгуунд *хасаг тэрэг, ямаан тэрэг* гэж нэрлэдэгийг судлагч, орчуулагч нар анзаараасай.

Qara, qara'u гэдэг үгийн анхны утга (колесо, колесница) эхний шатанд мартагдаад, дараагийн шатанд *qara'utai* (каре́та) мартагдаж, 13-14-р зууны үед түүний омоним *qara* (black) гэдэг үгээр ойлгогдох болсон байдал МНТ-ны хятад орчуулгаас мэдэгдэж байна.

- b) *ölzige* Их эртний үг. Утга тун тодорхойгүй. Орчуулагч нар “тэрэгний өмнөх суудал” the forefront (it seems, from this passage as well as those in §55 and 64 below, that the place occupied by the women was the front, inside the cart)⁹⁰ гэж боддог. Энэ ойлголт эргэлзээтэй, итгэхэд хэцүү юм.

Ölzige(n) гэдэг үгийн талаар би доорхи шинэ саналыг дэвшүүлж байна:

Ölzige(n) гэдэг бол нар ба борооны эсрэг хөнгөн дээвэртэй, сараалжин хашилга мэт хананууд нь сөхөж хааж болох исгий унжилга юмуу гэгээвчтэй, дотроо тохилог суудалтай, тэргэн дээр бэхэлж болох шүхэр⁹¹ хэлбэртэй хагас бүхээг (балдахин) юм. Тэрний эртний нэр *ölzige(n)* мартагдаад, одоогийн монгол хэлэнд *сэхээвч < сөхөвч < sekübcü* (портшез, паланкин) гэдэг болжээ.

Ölzige(n) гэдэг үгийн эртний утгыг түүний төрөл үндэс: *elgü-* (халх. *өлгө-*) ‘to hang, hang up, suspend’, *ölügei* (халх. *өлгий*) ‘baby’s cradle, swaddling clothes’, *öljei* ‘good luck, happiness’ гэдэг үгнээс мэдэрч болно.

- c) *qara'utai tergen-ü ölzige*⁹² Хөнгөн тэрэгний шүхэр буюу сэхээвч (балдахин на карете)

Зохиогчийн хөрвүүлгэ:

-Нэгэн хасаг (хөнгөн/ ямаан) тэргэний сэхээвчинд (сүйхэнд) нэгэн язгуур сайт охин⁹³ сууж явна (§ 6).

-[Ухаагчин эмгэн Бөртэ Үжсүнийг] бүхээгтэй хасаг тэргэнд суулгаж, бөөр алаг үхэр хөллөж (§ 100). -§55:

⁸⁸ С., Norjin *Mongyol kelen-ü toli, Čiyulultu Qaγaly-a qota*, 1999, 3142pp, p. 1246

⁸⁹ С., Norjin *Mongyol kelen-ü toli, Čiyulultu Qaγaly-a qota*, 1999, 3142pp, p. 1209

⁹⁰ F.W.Cleaves, *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary. Vol. I (translation). Harvard University Press, Cambridge, Mass., London, 1982, lxx + 277 pp. p. 2.

⁹¹ Лувсанданзан “Алтан Товч”-доо “qaryutai tergen” гэж хуулан бичээд qaryutai гэдэг үгний хажууд *sikür* (халх. *шүхэр*) гэдэг үг хадсан (Алтан товч (Lubsangdanjin) 1990, p. 5) яг оноогүй боловч ойртсон тайлбар байжээ. *Sikür* гэдэг үгээ *Ölzige(n)* гэдэг үгэнд хадсан бол онох байв.

⁹² Лувсанданзан “Алтан Товч”-доо *öljigede* гэдэг үгний хажууд *kötegei aral* (халх. *хөтгөр/гүдгэр арал*) гэсэн хадмал хийв (Алтан товч (Lubsangdanjin) 1990, p. 5). Хоёр урт модны хойт хэсгийг нарийн хөндлөвч моднуудаар сараалж болгон холбож тэргэний гол дээр суулгаж морь үхэр хөллөх хэрэгслийг *арал* гэдэг. Арал нь сараалж мэт юм болохоор Лувсанданзаны *хөтгэй / хөтгөр арал* гэсэн нь гүдгэр(босоо) сараалж хэлбэрт сэхээвчийг хэлсэн бололтой.

⁹³ Уг эхэд *nigen ökin sain bijü. Sain* гэдэг үгийн үндсэн утга *good*, метафор утга нь *aristocracy, aristocratic* байсан юм. Одоогийн монгол хэлний *caid* ‘minister’ гэдэг үг бол энэ метафор утгын олон тоот хэлбэрээс иржээ. Дува Сохорын хэлсэн *nigen ökin sain bijü* (§ 6) гэдэг бол *нэгэн язгуур сайт охин* (well-born, of illustrious or noble birth) байна гэсэн санаа буй заа.

<i>Oljige tutum</i>	Өлжигө тутам	here are
<i>Okid,</i>	Охид	Maidens
<i>Qarayututum</i>	Харай тутам	At every palanquin;
<i>Qatud bui</i>	Хатад бий.	Women
		At every chariot.

13. 3. Хам нөхцөлдөлгө ба тайлбар

Олон морь хөллөсөн, олон хигээст дугуйтай, зууван юмуу дөрвөлжин тэвштэй хөнгөн тэрэгний (колесницы) зурагууд Монгол Алтайн нурууны дагуухи нутгийн хадны зурагт олон тохиолддог. Энэ бол бидний энд ярьж байгаа *qara'utai tergen* –ий зурагууд мөн. Ийм тэрэг, Төв Азид их эрт цагт – карасукийн болон скитийн үеийн заагаар, барагцаалбал манай эриний өмнөх 8-р зуунд нэвтэрсэн гэдэг (“на рубеже карасукской и скифской эпох – эпох колесниц, ориентировочно 8 век до нашей эры”).⁹⁴

Монголын баруун хойт хөрш нар нь өндөр тэрэгтэй, цэнхэр нүдэт хүмүүс (динлины) байсан тухай эртний хятадын түүхэн сурвалжид тэмдэглэсэн, түрэг болон баруун хойт монголын зарим аймагийг “өндөр тэрэгтэн” гэж нэрлэсэн түүхийн мэдээ байдаг. МНТ-нд мэдээлснээр бол монголчууд, тэмээ хөллөсөн, сэхээвчтэй (*öljigetei*) өндөр тэргийг (*qara'utai tergen*) хаадын бэр буулгах сүйх (свадебный экипаж) болгон хэрэглэдэг байсан. Бэр охиныг суулгадаг тэр тэргийг *Qayan boluysan tan-u Qasay tergen* ‘Chariot cart which is ours Qahan’ (§ 64) гэж бас нэрлэдэг байсан тухай онцлон дурдсанаас гадна Чингис хааны эх, түүнийг яаралтай явдалын унаа болгон хэрэглэсэн тухай бичсэн нь ноцтой мэдээлэл юм. Ноцтой гэхийн учир юу вэ гэвэл Чингис хаан, төрсөн дүүгээ (Хасар) баривчлууж зовоохоор зэхэж байгаа мэдээг авсан эх, Чингис хаанруу мориор давхиж болох байсан. Гэвч тэмээ хөлөглөсөн хараутай тэргийг (бэр буулгаж нуган үр төрүүлж хүй залгасаны бэлгэдэл) сонгосон нь учиртай байжээ. Эх, хараутай тэргээр ирсэн, завилж суусан, хоёр хөхөөн гаргаж өвдөг дээрээ барисан, тэгээд Чингис хааныг хилэгнэн загнасан. Эхийн үгэнд: харж байна уу, хөхсөн хөх чинь энэ байна, хавиргаан хадрагсад, хүйгээн таслагсад... гэж гарч байгаа бүгдээр этно сурган хүмүүжүүлэх зүйн эртний уламжлалт нэгэн цогц арга ажээ.

Qara'utai tergen-ü öljige бол эрхэмсэг эмэгтэйн суудал, хаадын хуримын бэлгэдэл – үр хүүхэд төрж өлзий гарахын орон (place of good luck, happiness) байсан. Монголчуудын метафор сэтгэлгээний ариун үгс: *ölügei* /өлгий/ ‘baby’s cradle, swaddling clothes’, *öljei* /өлзий/ ‘auspice, favorable omen, happiness, good luck’ гэдэг үгстэй нэг гаралтай, нэгдмэл утгатай “*öljige*” бол Эхийн эрхэт ёсноос ирэлтэй гэгээн дурсгал болон уламжлагджээ.

Жич тэмдэглэх нь:

Qasay tergen (халх. *хасаг тэрэг*) гэдэг нэрийг Kazakh-аас юмуу Kirgiz –ээс ирэлтэй тэрэг гэж зарим хүмүүс боддог. Орос хэлэнд “буквально *казахская телега*”⁹⁵ гэж, англи

⁹⁴ Э.А.Новгородова, *Искусство ранних кочевников Монголии* (в кн.Роль кочевых народов в цивилизации Центральной Азии / Role of the Nomadic peoples in the civilization of Central Asia (A record of papers and discussions of the International UNESCO symposium, Улан-Батор, 1974, pp. 224 – 225.

⁹⁵ Большой Академический Монгольско-русский словарь в четырех томах, под общей редакцией А.Лувсандэндэва и Ц. Цэдэндамба, около 70 000 слов, Москва, “Academia” 2001, Т.IY, p. 65

хэлэнд “I.e., Kirgiz”⁹⁶ гэж орчуулсан нь ч бий. Гэвч энэ бол эргэлзээтэй зүйл. Учир нь *qasaγ* (*хасаγ*) гэдэг үг бол монгол хэлэнд 1) *тулганы хасаγ* ‘обруч или кольцо тагана’, 2) *шатрын тэрэг* ‘ладья’, 3) *тэрэгний дугуй*, 4) *хоёр дугуйт тэрэг* ‘two-wheeled cart’, 5) *бүхээгт тэрэг* ‘awning or cover on a vehicle, shack, hut’, 6) *тэрэг* ‘cart’ – ийм 6 утгаар тохиолддог юм.

13.4. Гадаад хэлнээ орчуулсан байдал

- Орос:** -Хороша молодица в кибитке **крытой повозки**,
-Спасая Борте-учжину Хоахчин-эмген усадила
ее **крытый возок**, запрягла рябую в почках
корову.⁹⁷
- Герман:** -befindet sich auf dem Vordersitz eines
schwarzen Karrens ein schönes Mädchen⁹⁸
-Die alte Frau Cho’agtschin aber setzte die Borte
udschin, um sie zu verbergen, auf **einen**
schwarzen Deichselkarren, spannte ein an den
Flanken geschecktes Rind davor⁹⁹
- Чех:** -sedí na **předním sedadle vozu** krásná dívka.
-Stará Choachčín posadila však Börte-üdžin, aby ji
skryla, **na černou káru**, zapřáhla do ni dobytče
se strakatými boky¹⁰⁰
- Англи:** -**At the forefront of one black cart** are drawing
nigh, one maiden is good.¹⁰¹
-Old Woman Qo’ayčín, saying, “I shall hide Börte
Üjin,” Making her to ride in a *böken*, **black cart**,
Harnessed [to it] an ox speckled of loins.¹⁰²
- Франц:** -il y a une fille, assise à l’avant d’un **chariot noir**,
qui est bien jolie! dit-il.¹⁰³
-Grand-mère Fauvine, voulant cacher Dame
Bleutée, la fit grimper dans un
chariot noir et y attela un bœuf à la croupe pie.¹⁰⁴

⁹⁶ F.W.Cleaves, *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary. Vol. I (translation). Harvard University Press, Cambridge, Mass., London, 1982, lxx + 277 pp. p. 16

⁹⁷ С.А.Козин, *Сокровенное сказание*, “введение в изучение памятника, перевод, тексты, глоссарии”. М.-Л., 1941, 619 pp. p.79 ; p. 9

⁹⁸ E.Haenisch, *Die Geheime Geschichte der Mongolen*. Leipzig, 1948, 196 pp. p. 1.

⁹⁹ E.Haenisch, *Die Geheime Geschichte der Mongolen*. Leipzig, 1948, 196 pp. p. 22.

¹⁰⁰ P.Poucha, *Tajná kronika Mongolů* [Secret Chronicle of the Mongols]. Praha, 1955, 279 pp. p. 12, p. 39.

¹⁰¹ F.W.Cleaves, *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary. Vol. I (translation). Harvard University Press. Cambridge. Mass., London. 1982, lxx + 277 pp. p. 2.

¹⁰² F.W.Cleaves, *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary. Vol. I (translation). Harvard University Press, Cambridge, Mass., London, 1982, lxx + 277 pp. p. 34.

¹⁰³ M.D.Even Pop, R., 1994, *Histoire secrète des Mongols*. Gallimard, UNESCO, 350 pp. p. 41.

¹⁰⁴ M.D.Even Pop, R., 1994, *Histoire secrète des Mongols*. Gallimard, UNESCO, 350 pp. p. 69.

14. Төгсгөл

МНТ бол түүхийн дурсгал болохоор хуучин үг ихтэй, уран зохиолын дурсгал болохоор уран үг ихтэй юм. Уран үгсийн оньс нь метафор хэлц юм. Тэрний түлхүүр нь этносын сэтгэлгээний аргыг эзэмших явдал болно. Энэ тийм амар юм биш нь мэдээж. Метафорыг уг хэлтний бичиг үл мэдэгч ойлгож байхад гадаадын монголч орчуулагч мэдрэхгүй байж болно. Би энэ өгүүлэлд МНТ-ны орчуулагчид ба судлагчдын дунд маргаантай, ойлгох ба тайлбарлахад төвөгтэй үг хэллэгүүээс сонгон авсны учир нь тэдний анхаарлыг МНТ-ны метафор судлалд хандуулах санаатай юм. Энэ өгүүлэлийг бичигчийн метафор судлалын сэтгэлгээ удаан хугацаанд хаалттай явж байгаад бараг санамсаргүй тохиолдлоор онгойж МНТ судлал руу хожимдон орсон тухайгаа өмнөх өгүүлэлийн төгсгөл үгэнд бичсэн билээ.¹⁰⁵

МНТ-ны олон хэлний орчуулгыг ажиглахад орчуулга улам сайжирсаар байгаа нь тодорхой боловч метафор хэлцүүдийг ихэнхдээ үгчлэн орчуулсныг үзэж мэдээд энэ “дутагдлыг” засахад бага боловч тус нэмэр болохыг би бодсон юм.

Метафорчлал заавал айзамт холбоо хэллэг ба уран шүлэг, зүйр цэцэн үгээр илрэх албагүй. Өнгөц харахад хэнд ч ойлгомжтой ердийн үгсийн цаана ч метафорчлал нуугдаж байгааг ганц хоёр жишээгээр үзүүлж энэ өгүүлэлийг төгсгөө.

öki (§54)

Үндсэн утга:

дээж, охь, охь дээж ‘spirit, top, essence, substance, source’; *olqunud ayimay-ača öki (oki) ab-* (§54) to take spirit of the Olqunud peoples. Метафор утга эхнэр, гэргий, бэр ‘bride, wife’; *olqunud ayimay-ača öki ab-* (§54) to take bride of the Olqunud peoples.

Бичвэр: *Mergid-ün Yeke-Čiledü Olqunuygud irgen-eče öki abči egüskejü ayisuqu-yi jolgaju...*

Гадаад хэлнээ орчуулсан байдал:

Орос: повстречал Меркитского Экэ-Чиледу, который ехал со свадьбы, взял себе девушку из Олхонутского племени¹⁰⁶

Англи: having taken a maiden from the Olqnu’ud people and having made [her] to arise, was drawing nigh.¹⁰⁷

Франц: qui avait pris une épouse chez les Olqunu’ud et la ramenait chez lui.¹⁰⁸

Чех: ktery si vezl dívku od lidu olchunuutského a tudy jel¹⁰⁹

¹⁰⁵ J.Lubsangdorji, *The Secret History of the Mongols in the mirror of metaphors*, in *Mongolica Pragensia* ’06, Prague, 2006, pp. 141-161. p. 159-160

¹⁰⁶ С.А.Козин, *Сокровенное сказание, “введение в изучение памятника, перевод, тексты, глоссарии”*. М.-Л., 1941, 619 pp. p.84

¹⁰⁷ F.W.Cleaves, *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary. Vol. I (translation). Harvard University Press, Cambridge, Mass., London, 1982, lxx + 277 pp. p. 34.

¹⁰⁸ M.D.Even Pop, R., 1994, *Histoire secrète des Mongols*. Gallimard, UNESCO, 350 pp. p.48

¹⁰⁹ P.Poucha, *Tajná kronika Mongolů* [Secret Chronicle of the Mongols]. Praha, 1955, 279 pp. p.19

asarayul- (§111):

Үндсэн утга:

асрамжлуул- ; метафор утга (эерүүлэл): *татвар эм болгон өг-*

Бичвэр:

Börte Üjin-i Čilger Bökü-de asarayuluysan ajuu (Бөртэ Үжинийг Чилгэрбөхөд татвар болгон өгсөн ажгуу).

Гадаад хэлнээ орчуулсан байдал:

Орос: Ее они передали на волю Чильгер-Бок¹¹⁰

Англи: made her to be cared for by Čilger Bökö¹¹¹

Франц: ... et en avaient confié le soin à Gaillard-le Lutteur (Čilger-Bökö).¹¹²

Чех: ... a dali ji pod ochranu Čilger-bököovi¹¹³

kebtögül- (§ 227, l. 30.)

Үнэмлэхүй ижил үгс (Absolute homonyms):

a) *хэвтэ-* гэдэг үйл үгийн үйлдүүлэх хэв [caus. of *kebte-* 'to lie down'] To cause someone or something to lie down;

b) *хэвтэ-* (*хэв* < *keb* гэдэг үгийн мартагдсан утга нь *хэв хууль*, *хэв ёс* зэрэг хоршоо үгэнд байна. Эртний утга нь *хууль*, *ёс*, *журам*, *дүрэм*. *Хэв* (*keb*) гэдэг нэр үгэнд *-тэ/те* дагавар залган *хэвтэ-* < *keb+te* гэдэг үйл үг (*хэвт оруул-*) бүтээж цааш үйлдүүлэх хэвд оруулсан хэл зүйн бүтэц бүхий *хэвтүүл-* < *kebtögül* гэсэн үгийн эртний утга нь *хэвийн* (*хуулийн*) *ёсыг дагуулан үйлдэ-, үйлдүүл-* ([caus. of *kebte-* 'to observe rule; *kebte-* < *keb* 'customary rule'] To cause someone to observe customary rule) гэсэн утгатай байсан гэж үзэж байна.

Бичвэр:

Nisiydaqun yosutan bögesü kebtögüljü nisid-že (Занчигдах ёстон бөгөөс хэв хуулийн ёсоор занчигдам-за).

Жич тэмдэглэхэд, Чингис хаан өөрийн Хишигтэний тоог түм хүргэж өөрчлөн байгуулаад тэдний тусгай дотоод хэв журмыг заасны дараа, Хэшигтэн нар журам тэрсэлбэл надад мэдэгдэж бай, надаас зөвшөөрөлгүйгээр тэднийг шийтгэж болохгүй, мөхирүүлэх ёстой бол бид мөхирүүлнэ, занчих ёстой бол бид занчина гээд цааш, хэрэвээ ахлагч нар дур зоргоороо Хэшигтэнд минь гар хөл хүргэж бэрээдвэл бэрээгийн хариу бэрээ, нударгын хариу нударгааар хариултугай! гэсэн өмөглөх модал санаатай зарлигт гарч

¹¹⁰ С.А.Козин, *Сокровенное сказание, "введение в изучение памятника, перевод, тексты, глоссарии"*. М.-Л., 1941, 619 pp. p. 103.

¹¹¹ F.W.CLEAVES, *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary. Vol. I (translation). Harvard University Press, Cambridge, Mass., London, 1982, lxx + 277 pp. p. 45.

¹¹² M.D.EVEN POP, R., 1994, *Histoire secrète des Mongols*. Gallimard, UNESCO, 350 pp. p.80

¹¹³ P.ROUCHA, *Tajná kronika Mongolů* [Secret Chronicle of the Mongols]. Praha, 1955, 279 pp. p.51

байгааг анзаарууштай. ... Газар хэвтүүлж байгаад занчиж бай гэж орчуулбал Чингис хаан зөвшөөрөхгүй биз ээ

Гадаад хэлнээ орчуулсан байдал:

- Орос:* ... разложить и наказывать палками тех, кто заслуживал палок¹¹⁴
- Англи:* If there be those for whom holdeth the rule that they are fit to be beaten, making [them] to lie down, [we] shall beat [them] (Cleaves 1982, p. 165-166).¹¹⁵
- Франц:* ... ; s'il y a raison de leur donner la bastonnade, nous le ferons allonger et nous les battons¹¹⁶
- Чех:* Jestliže si zasloužili potrestání bitím, máme je položit a bít¹¹⁷

¹¹⁴ С.А.Козин, *Сокровенное сказание, "введение в изучение памятника, перевод, тексты, глоссарии"*. М.-Л., 1941, 619 pp. p.170

¹¹⁵ F.W.Cleaves, *The Secret History of the Mongols*. For the first time done into English out of the original tongue and provided with an exegetical commentary. Vol. I (translation). Harvard University Press, Cambridge, Mass., London, 1982, lxv + 277 pp. p. 165-166


¹¹⁶ M.D.EVEN, POP, R., 1994, *Histoire secrète des Mongols*. Gallimard, UNESCO, 350 pp. p.193

¹¹⁷ P.Poucha, *Tajná kronika Mongolů* [Secret Chronicle of the Mongols]. Praha, 1955, 279 pp. p.169

Дагалт:

Охь авч үүсгэж айсах

Археологич нарын үзэж байгаагаар хүннүгийн үеийнх (I в. до н.э. – I – II в. н. э.) гэгдэх маш уран хадны зурагийг¹¹⁸ бид энэ өгүүлэлд дагалдуулж байна. Энэ зурагт хөнгөн тэрэгний *ölžige* (сэхээвч) маш тодорхой, гоё харагдаж байх бөгөөд дотор нь бүсгүй хүн (бэр) сууж байна. Хараутайд (*qara'utai tergen*) хөллөсөн гурвалсан морьдыг саадаг агссан морьтон эр (хүргэн) хөтөлж, нэг морьтон (бэрийн эцэг¹¹⁹ биз) үдэж явна! Энэ бол МНТ-ны үгээр *Öki abči egüskejü ayisuqu* (халх. *Охь авч үүсгэж айсах*) 'Having taken a maiden and having made [her] to arise, was drawing nigh' ? (§54) зураг байна. Сайн язгуурт овогоос (МНТ-д Олхунууд ба Хонгирад иргэн / *Olqunu'ud and Unggirad peoples*) бэр буулгах эртний уламжлалт тэр эрхэм зан үйлийг үзүүлэхдээ *Öljige, Qara'u, Qasay tergen, Öljigetei tergen* гэсэн Бэр буулгах сүйхийн (свадебный экипаж) нэр томъёонуудыг зориуд онцолсон оногдохуун болгон авч, эдгээр үгсийн эхний авиатай толгойн холбоц (начальная рифмовка) бүхий 24 мөр уран шүлэг холбосон нь (§ 64) “*Охь авч үүсгэж айсах*” ёсыг үгээр зурсан бас нэг гайхамшигт уран зураг ажээ.



Охь авч үүсгэж айсаж яваа зураг
(Хараутай тэргэний өлжигөд)

Ховд аймгийн Үенч сум, Ямаан Усны хавцалын Ханан Хад¹²⁰

¹¹⁸ Э.А.Новгородова, *Искусство ранних кочевников Монголии* (в кн.Роль кочевых народов в цивилизации Центральной Азии / Role of the Nomadic peoples in the civilization of Central Asia (A record of papers and discussions of the International UNESCO symposium), Улан-Батор, 1974, pp. 223 – 225. (Дорж, Новгородова 1975, p. 44; Цултэм 1986, p. 4.

¹¹⁹ Монголын хаан Амбагай (Тэмүжиний 4-р үеийн авга), бэр болсон охиноо үдэх замд дайсан аймагт баригдан алагдахын өмнө “*Хамагийн хаан, Уласын эзэн байж охиноо өөрөө хүргэхийг надаар хэсгээгтүн!* [saying, Beware, by me, of yourself accompanying your daughter, when ye will be *qahan* of all and Lord of the Nation (§53, Cleaves, 1982, p. 11)] гэж гэрээслэсэн болохоор Тэмүжинийг бэр буулгахад бэр болсон охиноо эх нь үдэж хүргэв (§94).

¹²⁰ Э.А.Новгородова, *Искусство ранних кочевников Монголии* (в кн.Роль кочевых народов в цивилизации Центральной Азии / Role of the Nomadic peoples in the civilization of Central Asia (A record of papers and discussions of the International UNESCO symposium), Улан-Батор, 1974, pp. 223 – 225. (Дорж, p. 75)

Товчилсон үг:

МНТ – Монголын Нууц Товчоо
халх. – халх аялгуу (одоогийн Ар Монголын хэл)
со. мо. – сонгодог монгол бичигийн хэл
эрт. мо. – эртний монгол хэл
Лу. - Лувсанданзаны

Abstract**The secret history of the mongols and metaphor**

The Secret History of the Mongols has been translated into many so-called world languages (for some of them 2-4 times). The meanings of old expressions and metaphors incorporating the patterns of the ancient language and thoughts of nomads have been forgotten or misunderstood quite frequently in the modern language. Since this process of misuse started even in the 13th century, mistakes were reflected already in the first Chinese translation. In other words, the first Chinese word-to-word translation has a number doubtful, sometimes clearly mistaken, expressions. Moreover some 40 words were left without a corresponding literal translation and it is not a secret that the translators of the SHM into the foreign languages restricted themselves forcedly with the Chinese meaningful translation. It is clear what happens if metaphors are translated literally, i.e. word-by-word. In Kozin's Russian translation the poetic passages were translated freely keeping the poetical sense, but providing with the underlined word-by-word translation in brackets. This type of translation is claimed by the author as the most relevant, even though the Kozin's literal translation is not free of inappropriate moments.